



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

Компанийн эзэмшигчдийн өмч дэх  
төрийн өмчийн дүн, дүрэмд өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бусад хөрөнгийн эх үүсвэрээр 2015-2017 онд хийгдсэн нийт 6,692,365,100 /зургаан тэрбум зургаан зуун ерөн хоёр сая гурван зуун жаран таван мянга нэг зуун/ төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1 дэх заалтанд “Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 270,736,439 /Хоёр зуун далан сая, долоон зуун гучин зургаан мянга, дөрвөн зуун гучин ес/ ширхэг хувьцаатай” гэснийг “Компани нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 337,660,090 /Гурван зуун гучин долоон сая, зургаан зуун жаран мянга, ерэн/ ширхэг хувьцаатай” гэж өөрчилсүгэй.

3. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнд орсон өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэхэд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002095